

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/011/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-2442 Цахим хаяг: bayasgalanj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	20-25
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	23-25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНС	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,447,648.1	1,503,423.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,104,785.6	1,093,828.5
33	АВЛАГА	261,115.1	323,575.8
35	БАРАА МАТЕРИАЛ	81,747.4	86,019.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,507,391.5	2,462,283.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,507,391.5	2,462,283.0
39200	Биет хөрөнгө	1,440,927.0	2,396,105.9
39300	Биет бус хөрөнгө	66,464.6	66,177.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,955,039.6	3,965,706.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,613.6	34,926.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,613.6	34,926.3
41300	Өглөг	15,613.6	34,926.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,939,426.0	3,930,780.6
51	Засгийн газрын хувь оролцоо	2,939,426.0	3,930,780.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	351,845.2	351,845.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,357,574.1	3,348,928.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,006.7	230,006.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,955,039.6	3,965,706.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,924,047.6	9,198,947.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	804,175.9	721,305.2
110	Орлогын албан татвар	178,564.7	378,100.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	190,912.0	413,003.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(12,347.3)	(34,902.2)
113	Хөрөнгийн албан татвар	37,773.2	43,783.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	587,838.0	299,421.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,262.2	636,448.5
120	Нийтлэг татварын бус орлого	347,262.2	636,448.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	772,609.5	1,841,193.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,165,298.1	1,687,323.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,298.1	1,687,323.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,142,285.4	1,637,381.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,152.2	715,022.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,312.3	88,363.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,342.0	344,798.1
2104	Хангамж, бараа материалын зардал	47,935.7	70,011.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,763.1	129,737.7
2107	Томиллолт, зочны зардал	16,164.0	19,407.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	330,730.6	14,456.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,885.4	255,585.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,012.7	49,941.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	758,749.5	1,511,624.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	322,776.6	520,269.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	435,972.9	991,354.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,503,453.2	-	2,503,453.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,503,453.2	-	2,503,453.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	435,972.9	-	435,972.9
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,939,426.0	-	2,939,426.0
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,939,426.0	-	2,939,426.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,939,426.0	-	2,939,426.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	991,354.5	-	991,354.5
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,930,780.6	-	3,930,780.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,738,999.7	2,628,869.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	804,175.9	721,305.2

110	Орлогын албан татвар	178,564.7	378,100.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	190,912.0	413,003.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(12,347.3)	(34,902.2)
113	Хөрөнгийн албан татвар	37,773.2	43,783.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	587,838.0	299,421.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	273,125.0	65,911.5
1181	Газрын төлбөр	139,924.3	61,398.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	174,788.7	172,111.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,214.3	66,370.5
120	Нийтлэг татварын бус орлого	162,214.3	66,370.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	772,609.5	1,841,193.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,061,072.1	1,511,091.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,061,072.1	1,511,091.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,040,514.4	1,467,614.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,416.9	714,892.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,467.1	87,884.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,342.0	344,798.1
2104	Хангамж, бараа материалын зардал	44,987.6	56,928.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,763.1	130,406.5
2107	Томилолт, зочны зардал	16,164.0	19,407.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	330,848.9	16,689.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,524.7	96,608.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,557.7	43,476.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	677,927.6	1,117,778.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	602,991.8	1,128,735.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	602,991.8	1,128,735.2
2200	Дотоод эх үүсвэрээр	602,991.8	1,128,735.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(602,991.8)	(1,128,735.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,935.8	(10,957.1)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,029,849.8	1,104,785.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,104,785.6	1,093,828.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,612,109,600.0	2,637,760,109.6	974,349,490.4	73.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,967,073,800.0	1,541,159,784.6	425,914,015.4	78.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,912,035,200.0	1,497,683,180.6	414,352,019.4	78.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,386,200.0	714,590,146.3	31,796,053.7	95.7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,576,200.0	87,884,555.2	6,691,644.8	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,243,300.0	344,798,080.6	64,445,219.4	84.3
2104	Хангамж, бараа материалын зардал	61,801,800.0	55,163,949.5	6,637,850.5	89.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,464,000.0	162,541,379.0	12,922,621.0	92.6
2107	Томилолт, зочны зардал	20,550,300.0	19,407,000.0	1,143,300.0	94.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,105,700.0	16,689,470.0	219,416,230.0	7.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,907,700.0	96,608,600.0	71,299,100.0	57.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,038,600.0	43,476,604.0	11,561,996.0	79.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,038,600.0	43,476,604.0	11,561,996.0	79.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,572,255,800.0	1,096,600,325.0	475,655,475.0	69.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	72,780,000.0	-	72,780,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,612,109,600.0	2,765,283,333.8	846,826,266.3	76.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,686,260,800.0	2,720,377,162.6	(34,116,362.6)	101.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	247,183,900.0	44,906,171.2	202,277,728.8	18.2
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	678,664,900.0	-	678,664,900.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	303,717,864.9	(303,717,864.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	431,241,089.1	(431,241,089.1)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54.0	54.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.0	26.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.0	26.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,066,604.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,066,604.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,066,604.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		301,912.0
2104	Хангамж, бараа материалын зардал		1,764,692.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-
2200	Дотоод эх үүсвэрээр		-

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,066,604.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,066,604.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Түшиг сумын ТТЗ гэх/ нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэж, төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Иргэдийн сэтгэл ханамжид суурилсан төрийн үйлчилгээний төгөлдөршлийг бүтээнэ,*
- *Нийтийн эрх ашгийг дээдлэн ажиллах,*
- *Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх,*
- *Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх,*
- *Ёс зүйн зөрчилгүй ажиллах,*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Түшиг сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд бие даасан хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагууд хяналт хэрэгжүүлж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Түшиг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,010,667.3 мянган төгрөгөөр буюу 34.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,104,785.6	1,093,828.5	(10,957.1)
Авлага	261,115.1	323,575.8	62,460.7
Бараа материал	81,747.4	86,019.6	4,272.2
Үндсэн хөрөнгө	1,507,391.5	2,462,283.0	954,891.5
Нийт хөрөнгө	2,955,039.6	3,965,706.9	1,010,667.3
Өр төлбөр	15,613.6	34,926.3	19,312.7
Засгийн газрын хувь оролцоо	2,939,426.0	3,930,780.6	991,354.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,955,039.6	3,965,706.9	1,010,667.3

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,093,828.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,957.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,104,785.6	1,093,828.5	(10,957.1)
Төгрөг	1,104,785.6	1,093,828.5	(10,957.1)
Төрийн сангийн харилцах	1,104,785.6	1,093,828.5	(10,957.1)
Дүн	1,104,785.6	1,093,828.5	(10,957.1)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 688,592.4 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 272,648.8 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 117,100.8 мянган төгрөг ХХС-ийн дансанд, 15,486.5 мянган төгрөг БХНС барьцаа дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 323,575.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,460.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	479.0	-	479.0
Зээлийн хүүгийн авлага	2,565.5	1,203.0	1,362.5
Байгууллагаас авах авлага	102,749.2	209,546.0	(106,796.8)
Хувь хүмүүсээс авах авлага	2,464.4	2,464.4	-
Хувь хүмүүст олгосон зээл	152,857.0	110,362.4	42,494.6
Дүн	261,115.1	323,575.8	(62,460.7)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 129,796.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ, сумын ОНХО-ын эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 79,749.2 мянган төгрөгийн наадмын талбайн тохижилтыг тус тус авлагаар бүртгэсэн,
- ОНХО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,464.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч тодорхойгүй/,
- ХХС-ийн зээлийн 109,159.3 мянган төгрөг, зээлийн хүүгийн 1,203.0 мянган төгрөгийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 86,019.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,272.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	81,747.4	86,019.6	4,272.2
Аж ахуйн материал	80,392.6	81,013.8	621.2
Түлш, шатах тослох материал	1,354.8	-	(1,354.8)
Бусад хангамжийн материал	-	5,005.8	5,005.8
Дүн	81,747.4	86,019.6	4,272.2

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 644,262.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, 5,005.8 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг шилжүүлэн авсан, 179,550.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон 465,445.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,462,283.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 954,891.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	672,649.6	748,998.9	76,349.3
Авто-тээврийн хэрэгсэл	30,927.2	284,045.6	253,118.4
Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,867.4	114,969.1	12,101.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	22,535.8	19,543.7	(2,992.1)
Зам, гүүрийн байгууламж	45,715.3	372,780.8	327,065.5
Бусад үндсэн хөрөнгө	566,231.7	855,767.8	289,536.1
Программ хангамж	718.7	431.3	(287.4)
Бусад биет бус хөрөнгө	65,745.8	65,745.8	-
Дүн	1,507,391.5	2,462,283.0	954,891.5

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32,134.9 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЗДТГ-ын автомашины граж, “Өнгөлөг гудамж” тохижилт, 20,000.0 мянган төгрөгийн тоглоомын талбай, эко зөөврийн нойл, нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа, хогийн цэгийн хашаа, өөрөө ачигч ковш, хог тээврийн машин,

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 140,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Форд ренжер автомашин үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар авто гражийн дулааны шугам,
- Төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т автомашины граж, 337,861.2 мянган төгрөгийн зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, 17,000.0 мянган төгрөгийн сур харвааны талбай, ЗДТГ-т эко бие засах газар, сумын төвийн камержуулалт, постны байр болон постны байранд цахилгаан холбох зэрэг төсөл, арга хэмжээг тус тус комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгаснаас шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 15,613.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 102,867.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	15,613.6	34,926.3	19,312.7
Дүн	15,613.6	34,926.3	19,312.7

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагыг авсан, ЗДТГ-ын гражийн барилгын үлдэгдэл төлбөр болох 19,312.6 мянган төгрөг зэргээс голлон шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,930,780.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 991,354.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	351,845.2	351,845.2	-
Хуримтлагдсан үр дүн	2,357,574.1	3,348,928.6	991,354.5
Өмнөх үеийн үр дүн	4,899,828.7	1,921,601.2	(2,978,227.5)
Тайлант үеийн үр дүн	435,972.9	991,354.5	555,381.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,006.7	230,006.7	-
Дүн	2,939,426.0	3,930,780.6	991,354.6

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Түшиг сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 121 дүгээр тогтоолоор тайлант онд 805,878.9 мянган төгрөгийн татварын орлого, 20,954.9 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **826,833.8** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **749,234.5** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 9.4 хувиар тасарсан байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

	<i>/мянган төгрөг/</i>			
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	805,878.9	721,305.2	(84,573.7)	89.5
Цалин хөлс шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	202,981.8	306,348.9	103,367.1	150.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(34,902.2)	(34,902.2)	(0.0)	100.0
Үйл ажиллагааны орлогын албан татвар	73,000.0	93,399.7	20,399.7	127.9
Хөрөнгийн орлого	10,429.3	11,230.5	801.2	107.7
Хөрөнгө борлуулсны орлого	2,471.0	2,024.0	(447.0)	81.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	5,000.0	1,083.8	(3,916.2)	21.7
Бууны татвар	2,300.0	1,208.0	(1,092.0)	52.5
Газрын төлбөр	-	37,898.5	37,898.5	
Газрын дуудлага худалдаа	10,000.0	23,500.0	13,500.0	235.0
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	2,961.8	(38.2)	98.7
Ан агнуурын нөөц	4,778.0	2,915.5	(1,862.5)	61.0
Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр	8,000.0	2,086.0	(5,914.0)	26.1
Түгээмэл тархац	269,500.0	62,949.7	(206,550.3)	23.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	100.0	-	(100.0)	-
Малд ногдуулсан албан татвар	62,157.6	41,491.5	(20,666.1)	66.8
Ойн нөөц ашигласны төлбөр	187,063.4	167,109.7	(19,953.7)	89.3
Татварын бус орлого	20,954.9	27,929.3	6,974.4	133.3
Хүү торгуулийн орлого	16,000.0	13,182.0	(2,818.0)	82.4
Хууль тогтоомжийн дагуу сумын төсөвт орох бусад орлого	2,900.0	12,504.5	9,604.5	431.2
Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	2,054.9	2,242.8	187.9	109.1
Нийт орлогын дүн	826,833.8	749,234.5	(77,599.3)	90.6

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан нь түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр гүйцэтгэлээр 206,550.3 мянган төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 20,666.0 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 19,953.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:**
Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн болон “Илч хужирт ХХК” урд оны өрөө төлсөнтэй холбоотойгоор,
- **Үйл ажиллагааны орлогын албан татвар:**
“Эрдэнэс таван толгой” ХК хувьцааны ногдол ашиг тараасантай холбоотой ХХОАТ-ын дүн нэмэгдсэн,
- **Газрын дуудлага худалдаа:**
Газрын дуудлага худалдаанд тооцоолсноос олон иргэд оролцон газрын үнэ өссөнөөс
Бусад орлого:
2023 оны жилийн эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн орлого болон сумын 100 жилийн ойгоор худалдаа үйлчилгээ эрхлэх иргэдээс хураамж төлөгдсөнөөс тус тус шалтгаалсан байна.

Тасарсан орлого:

- **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:**
Орлогыг хэт өндрөөр төлөвлөсөн,
- **Ан агнуурын нөөц:**
Ан агнуурын зөвшөөрөл олгох эрхийг цөөн тоогоор баталсан, сумын ИТХ-аас загас агнуурыг хориглосон тогтоол гаргасан,
- **Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр:**
2024 онд самар болон жимс ургаагүй,
- **Түгээмэл тархац:**
Замын компани гэрээний дагуу хайрганы төлбөр төвлөрүүлээгүйгээс шалтгаалж 206,550.3 мянган төгрөг,
- **Малд ногдуулсан албан татвар:**
Малчдаас авах татварыг бүрэн төвлөрүүлээгүйгээс,
- **Ойн нөөц ашигласны төлбөр:**
Төлөвлөгөөг аймгийн ИТХ-аас баталсан мод бэлтгэх модны хуваариас хэтрүүлэн төлөвлөсөн гэх мэт.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,452,039.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 142 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,046,863.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 645,968.2 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 95 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 695,186.3 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,046,863.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 645,968.2 мянган төгрөг, ОНХС-ийн төсвийн урьд оны үлдэгдэл 118,841.1 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны үлдэгдэл

944,211.4 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын урьд оны үлдэгдэл 52,842.5 мянган төгрөг, өөрийн орлогыг 500.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 75,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг **3,579,412.9** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 137,352.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 1,184,215.6 мянган төгрөг болгон баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор аймгаас олгох ОНХС-ийн шилжүүлгийг 32,696.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн орлого, зарлагыг **3,612,109.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 39 арга хэмжээг санхүүжүүлэхээр **3,612,109.6** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,964,853.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,572,255.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 75,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 1,184,215.6 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 826,833.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 675,211.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 75,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 678,664.9 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 171,683.9 мянган төгрөгийг, 500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	224,653.0	196,151.5	28,501.5	87.3
2	Засаг даргын тамгын газар	1,319,693.5	976,492.4	343,201.1	73.9
3	Орон нутгийн хөрөнгө оруулалт	659,749.5	483,442.9	176,306.6	73.2
4	Орон нутгийн хөгжлийн сан	912,506.3	613,157.3	299,349.0	67.1
5	Хоршоо хөгжүүлэх сан	75,000.0	150.0	74,850.0	0.2
6	ЕБС	219,859.5	202,118.8	17,740.7	91.9
7	Эрүүл мэндийн төв	81,298.8	49,912.8	31,386.0	61.3
8	Цэцэрлэг	70,532.0	67,855.9	2,676.1	96.2
9	Соёлын төв	48,817.0	48,478.5	338.5	99.3
	Нийт дүн	3,612,109.6	2,637,760.1	974,349.5	73.0

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 1,184,215.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 749,234.5 мянган төгрөг, өөрийн орлогоос 478.8 мянган төгрөг, ОНХС-аас 654,911.7 мянган төгрөг, орон нутгийн урд оны үлдэгдлээс 48,769.5 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 150.0 мянган төгрөг нийт 2,637,760.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,637,760.1** мянган төгрөг буюу 73.0 хувьтай байгаа нь урсгал зардлыг 425,914.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 475,655.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 74,850.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 38,487.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 64,445.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 6,637.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 12,922.6 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 1,143.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 219,416.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 11,561.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 71,299.1 мянган төгрөгөөр зэрэг нийт 974,349.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 21 төсөл, арга хэмжээнд 912,506.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 613,157.3 мянган төгрөг олгож, 314,140.3 мянган төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд үлдэгдэлтэй байна.

ХХС-аас 75,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч зээл олгогдоогүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 334.5 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 793.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 938.3 мянган төгрөг зэрэг нийт 2,066.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 301.9 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 1,764.7 мянган төгрөг,

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС, ОНХО, урсгал зардлын төсвөөс 1,572,255.8 мянган төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулах 2 төсөл, арга хэмжээ, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 14 төсөл, арга хэмжээ, шууд худалдан авалтаар 14, нийт 30 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Түшиг сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

Имянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			ШХА		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	12	659,749.5	6	75,923.4	5	245,150.0	1	338,676.1
Сумын ОНХС	18	841,950.4	8	147,696.7	9	494,253.4	1	200,000.0
Дүн	30	1,501,699.9	14	223,620.1	14	739,403.4	2	538,676.1

Эх сурвалж: tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөрөнгийн тооллого, төсвийн төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1,165,298.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,652.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг автомашинуудад төрийн албаны цэнхэр дугаарыг хэрэглэж байна.
- Хэмнэлтийн хуулиар хориглосон тавилга эд хогшил худалдан авах, шуудан холбоо, нормын хувцас худалдан авах, суудлын автомашин авах зэрэг зардал төлөвлөн зарцуулаагүй байна.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нийцэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Засаг даргын захирамжаар Түшиг сумын 100 жилийн ойн баримтат кино бүтээх ажлын гэрээг Улс сүлд ХХК-тай байгуулан 30,000.0 мянган төгрөг, видео контент хийлгэхээр Монголын баялаг өв соёл ХХК-тай 4,879.6 мянган төгрөгийн гэрээ байгуулан нийт **34,879.6** мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниуулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	169	9
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	175	7
3	Сумын Засаг даргын Тамгын газар	182	175	7
	Нийт дүн	542	519	23

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1. Тайлант хугацаанд Түшиг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 542 мэдээллээс 519 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 171 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,480.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 33,013.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 89,185.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,480.5	1	1,480.5	100
Албан шаардлага	4	33,013.8	4	33,013.8	100
Зөвлөмж	3	89,185.0	3	89,185.0	100
Нийт дүн	8	123,679.3	8	123,679.3	100

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулаагүй алдаа:

Аудитаар Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 129,796.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ, сумын ОНХО-ын эх үүсвэрээр санхүүжсэн, хэрэгжиж дуусаагүй 79,749.2 мянган төгрөгийн наадмын талбайн тохижилт зэрэг нийт **209,546.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг дуусаагүй үйлдвэрлэлд бус авлагаар бүртгэж, тайлагнасан алдаа илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4: “үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар нийт **81,580.8** мянган төгрөгийн зөрчил илэрч, 3 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага:

1. Батлагдсан төсвийг зардлын бүлэг, арга хэмжээ хооронд гүйлгэн, **900.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

Сумын ЗДТГ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450,0 мянган төгрөгийн программын төлбөрийг Си Ти Эс ХХК-д шилжүүлсэн,

Сумын ИТХ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450,0 мянган төгрөгийн программын төлбөрийг Си Ти Эс ХХК-д шилжүүлсэн,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”,

2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс **3,081.6** мянган төгрөгийг жил бүр давтагдан гардаг, төлөвлөх боломжтой, тохижилт үйлчилгээний зардал буюу нохой устгахад зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1 дэх “*Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна: 3.1.2: урьдчилан төлөвлөх боломжтой....зардал ...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг **77,599.2** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дуусаагүй үйлдвэрлэлийг авлагаар тайлагнаж бүртгэсэн.	1	209,546.0			1	209,546.0			1	209,546.0	1	209,546.0
Дүн	1	209,546.0			1	209,546.0			1	209,546.0	1	209,546.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	80,680.8			2	80,680.8						
ИТХ,	1	450.0			1	450.0						
ЗДТГ	1	450.0			1	450.0						
Дүн	3	81,580.8			3	81,580.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудсанд 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1							1	
Дүн	1							1	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил									
Баримтат кино, видео контент хийлгэсэн.	1	34,879.6			1	34,879.6			
Дүн	1	34,879.6	-	-	1	34,879.6			
Нийт дүн	2	34,879.6			1	34,879.6		1	